

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал .....	12
3.1. Бараа материалын данстай холбоотой асуудал.....	12
3.1.2 Эрсдэл: Зардлыг дутуу бүртгэсэн байх.....	12
3.2. Орлогын данстай холбоотой асуудал .....	12
3.2.2. Эрсдэл: Орлогыг аккруэл сууриар бүртгээгүй байх, дутуу төвлөрүүлэх; .....	12
4. Аудит хийсэн Санхүүгийн тайлан .....	14
4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	16
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЯРЦОГТ  
ТАНАА

2020.03.13 № 06/775  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлогыг аккруэл сууриар тайлагнах, бараа материалыг холбогдох стандартын дагуу бүртгэх зэрэг асуудлуудтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 14-өөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Мишээл-Од Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1/107 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь “Бид найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчийг түгээхдээ хэрэглэгчээ хүндэлж, нийгмийн хариуцлагыг эрхэмлэн, аюулгүй ажиллагааг ханган ажиллана” гэсэн эрхэм зорилгын хүрээнд Монгол Улсын нийт 11 аймгийн 124 сум суурин газрын 76,613 хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг түгээх, хангах үйл ажиллагааг 35, 15, 10, 6, 0.4 кВт-ын 5,970.6 км дамжуулах шугам сүлжээ, төрийн эзэмшлийн 623, хувийн болон бусдын эзэмшлийн 655, нийт 1,278 дэд станц, хуваарилах байгууламжийг ашиглан Булган, Архангай, Өвөрхангай, Хархорин гэсэн 4 салбартай үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь дараах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч түгээх
- Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх /0,4-35кВт хүртэл/
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /0,4-35кВт хүртэл/
- Монгол Улсад зөвшөөрөгдсөн загварын цахилгаан эрчим хүчний 1 ба 3 фазын механик, электрон, импульсийн тоолуур гүйдлийн трансформатор засварлах, тохируулах, суурилуулах, худалдах
- Цахилгаанчин давтан мэргэшүүлэх сургалт явуулах
- ХАБЭА-н сургалт зохион байгуулах

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашин эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт,

холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд батлагдсан бодлого, журамд нийцүүлэн 2017 онд шинээр боловсруулан мөрдөж байна.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшнийг их гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 174,298.9 сая төгрөгөөс тооцон 871.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 248,717.1 сая төгрөгөөс 1,243.6 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,753.7 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /сая төгрөг/
Мөнгөн хөрөнгө	3,624.4	1,676.0	(1,948.4)
Авлага	12,350.0	11,681.6	(668.4)
Урьдчилгаа	449.2	1,241.9	792.7
Бараа материал	2,473.7	2,640.4	166.7
Үндсэн хөрөнгө	118,119.4	128,530.5	10,411.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>137,016.7</b>	<b>145,770.4</b>	<b>8,753.7</b>
Өр төлбөр	17,653.8	21,726.4	4,072.6
Эздийн өмч	119,535.0	41,897.0	(77,638.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	82,711.3	82,711.3
Эздийн өмчийн бусад хэсэг	2,574.7	2,574.7	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(2,746.8)	(3,138.9)	(392.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>137,016.7</b>	<b>145,770.4</b>	<b>8,753.7</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,948.4 сая төгрөгөөр буурсан нь 2019 оны 9 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр 2,596.8 сая төгрөгийн их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал, хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэрт ашиглахаар шийдвэр гарсны дагуу зарцуулалт хийсэн нь шалтгаалжээ.

Авлага дансны 11,681.6 сая төгрөгийн үлдэгдэл нь тайлант оны 12 дугаар сард үүссэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас авах 11,575.0 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний авлага, 2014 оноос өмнө үүссэн худалдан авах ажиллагаатай холбоотой 65.8 сая төгрөгийн эрсдэл бүхий авлага байна. Тайлант онд авлагын үлдэгдэл 668.4 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна.

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас цахилгаан эрчим хүчний авлага 543.5 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагаас авах цахилгаан эрчим хүчний авлага 223.1 сая төгрөгөөр буурсан;
- Эрчим хүчний төсөл-2 хэрэгжиж байгаатай уялдан борлуулалтын циклд өөрчлөлт орсноос төсөвт байгууллага, айл өрхөөс авах цахилгаан эрчим хүчний авлага 141.9 сая төгрөгөөр өссөн;
- Бусад авлага 43.9 сая төгрөгөөр буурч, 8.4 сая төгрөгөөр өссөн шалтгаанууд нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 166.7 сая төгрөгөөр өссөн нь цахилгааны сэлбэг хэрэгсэл 74.7 сая төгрөгөөр, авто техник хэрэгслийн сэлбэг 46.8 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгаалал болон бусад бараа материал 92.0 сая төгрөгөөр тус тус өсөж, хангамжийн материал 44.7 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал дансны 1,241.9 сая төгрөгийн үлдэгдэлд дараах урьдчилгаа төлбөрүүд Үүнд:

- Эрчим хүчний төсөл-2 хэрэгжсэнтэй холбоотой тус компанид хуваарилсан төсөл хариуцсан нэгжид хамаарах 549.2 сая төгрөгийн зардал;
- Тус төслийн хүрээнд хүлээн авсан зээлийн үлдэгдэлд хамаарах болон ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд хамаарах 384.4 сая төгрөгийн хүүгийн зардал;
- “Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд хийгдэж байгаа дуусаагүй барилгад хуваарилагдах 233.8 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлд төлсөн урьдчилгаа төлбөр зэрэг “Эрчим хүчний төсөл 2”-той холбоотой ажлын гүйцэтгэл дууссаны дараа хуваарилагдах зардлууд байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд өөрийн хөрөнгөөр 7,610.8 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,752.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,411.1 сая төгрөгөөр өссөн нь барилга байгууламж 8,466.8 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 1,502.9 сая төгрөг, тоног төхөөрөмж 268.5 сая төгрөг, тавилга эд хогшил 115.9 сая төгрөг, бусад хөрөнгө 818.1 сая төгрөгөөр өсөж, тайлант үеийн элэгдлийн зардал 6,565.6 сая төгрөгөөр нэмэгдэж, дуусаагүй барилга 5,603.9 сая төгрөгөөр өссөн, ТӨБЗГ-ын 2019 оны А-1/4050 болон 618 дугаар тогтоолыг үндэслэн 191.0 сая төгрөгийн биет хөрөнгө акталж, данснаас хассантай тус тус холбоотой байна.

Дуусаагүй барилга дансны 6,173.4 сая төгрөгийн үлдэгдэл нь өөрийн хөрөнгөөр баригдаж байгаа 491.6 сая төгрөгийн цахилгаан дамжуулах агаарын шугам, “Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд тус компанийн 3 салбарт 5,681.7 сая төгрөгийн агаарын шугам, дэд станцууд баригдаж байгаатай холбоотой байна. Эдгээр барилга угсралтын ажлууд нь 2020 онд баригдаж дуусахаар төлөвлөгдсөн байна.

Биет бус хөрөнгө 35.1 сая төгрөгөөр өссөн нь газар эзэмших эрх шинээр 1,100 м<sup>2</sup> буюу 44.0 сая төгрөгөөр, техникийн алдагдлын LOSS программын сайжруулалт 15.0 сая төгрөг, санхүүгийн Unicus системийн сайжруулалт 5.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн хорогдуулалтын зардал 29.8 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.



Өр төлбөр дансны үлдэгдэл 4,072.6 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлбөр 1,504.2 сая төгрөгөөр, эрсдэлийн сангийн нөөц 26.4 сая төгрөгөөр, хүүгийн өглөг 61.7 сая төгрөгөөр, татварын өр 83.1 сая төгрөгөөр, бусад өглөг 102.6 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлого 27.3 сая төгрөгөөр тус тус буурч, бэлтгэн нийлүүлэгчийн өглөг 104.2 сая төгрөгөөр, урт хугацаат өглөг 5,783.2 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр “Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд тайлант онд 2,398,548.74 ам долларын зээл хүлээн авч, оны эцэст 6,686.4 сая төгрөг болсон ба Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д төлөх “Эрчим хүчний төсөл-1” төслийн зээл 3.1 сая төгрөгөөр буурсан байна. Хойшлогдсон орлогын хэрэгжилт 118.9 сая төгрөгөөр буурч, өмнөх тайлант үеийн алдааны залруулга 613.8 сая төгрөгөөр хойшлогдсон орлогын дүн буурсан байна.

Эзний өмч дансанд 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор 786.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шилжүүлэн бүртгэж, хойшлогдсон орлогын хэрэгжилт 118.9 сая төгрөг, өмнөх тайлант үеийн алдааны залруулга 613.8 сая төгрөгөөр буурч, Хархорин салбарт 722.6 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга угсралтын ажлын дүнгээр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 82,711.3 сая төгрөг байна. 2015 оны дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү 82,251.7 сая төгрөгөөр өмчийн дүн буурч, 2015 ба 2018 оны дахин үнэлгээний тайлант үеийн олз, гарзын зөрүү 459.6 сая төгрөгөөр хуримтлагдсан ашиг буурсан байна.

## **2.9. Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2019 оны 224 дүгээр тушаалаар Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна.

Тайлант онд орлогыг 250,007.2 сая төгрөгөөр баталсныг 248,717.1 сая төгрөгөөр биелүүлж, 1,290.1 сая төгрөг буюу 0.5 хувиар тасалдуулсан байна. Мөн өмнөх оноос орлого 1,134.1 сая төгрөгөөр буурсан нь борлуулахаар худалдаж авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ 1,196.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь тайлант онд 1,176.1 сая кВтц цахилгаан эрчим хүч худалдан авч 247,742.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, бусад ажил үйлчилгээнээс 746.0 сая төгрөгийн, хүүгийн орлогоос 228.6 сая төгрөгийн бүгд 248,717.1 сая төгрөгийн орлого олж, эрчим хүч худалдан авсны төлбөрт 223,682.9 сая төгрөгийг төлж, 24,867.0 сая төгрөгийг үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд зарцуулж, 68.8 сая төгрөгийн татварын зардал үүсгэж, 98.4 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Техник зохион байгуулалтын арга хэмжээ, их засвар, хөрөнгө оруулалтын 153 ажилд 8,948.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 153 ажилд 7,807.8 сая төгрөгийг зарцуулж 1,141.0 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,088.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 959.2 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 128.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Дараах 959.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тус компанийн өмчлөлийн Булган аймгийн Хялганат тосгонд байрлах 43.3 сая төгрөгийн өртөгтэй, 35 дугаар байрны 2 давхарт байрлах 2 өрөө байрыг хэрэглэгчдэд үйлчлэхэд хялбар гэж үзэн 2013 онд 1 давхрын 2 өрөө байраар сольж үйл ажиллагаагаа явуулж байсан боловч тус байрны өмчлөгч 1 давхрын байраа буцаан авахаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Анхан шатны шүүхийн шийдвэрээр Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг албадан гаргах шийдвэр гаргасан, энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Бэлтгэн нийлүүлэгчид болон хувь хүнтэй холбоотой 7 харилцагчийн 64.2 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний борлуулалттай холбоотой 42 харилцагчийн 12.6 сая төгрөг, нийт 76.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Аваарын нөөцөд бүртгэлтэй трансформаторуудаас түүвэрлэн биет тооллого хийхэд ТМ-35/15 1000 кв маркийн 43.6 сая төгрөгийн трансформатор биетээр оршин байхгүй байсан ба тус трансформаторыг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн улмаас Говь-Алтай аймгийн Жаргалан, Баян-Уул зэрэг сумууд сар гаруй хугацаанд цахилгаан хангамжгүй болсон тул Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-д Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангаагүй 795.5 сая төгрөгийн 11 оролцогчийг тендерт шалгаруулсан, тендерийн баримт бичгийн зарим заалтуудыг алдаатай боловсруулсан, тендерийн урилгад ирүүлэхээр заагдсан баримтыг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгаагүй, нээлтийн хурлын тэмдэглэлийг хуулийн дагуу хөтлөөгүй зэрэг зөрчлүүд илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ” 27.1.1-д “энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага” 27.1.2-д “техникийн тодорхойлолт” 27.1.3-д “тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага” 27.3-т “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” 27.4-д “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад

нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

5. Тайлант онд 250,007.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан байхад гүйцэтгэлээр 248,717.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 1,290.1 сая төгрөг буюу 0.5 хувиар орлогыг төлөвлөгөөг тасалдуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Захирал дараах эрх, үүрэгтэй”, 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар 128.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Улсын Их Хурлын 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолоор тус компанид 2017-2022 онуудад Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр Эрчим хүчний төсөл-2 хэрэгжиж, төслийн хүрээнд Орхон, Архангай, Өвөрхангай, Булган аймгийн төвүүд, Өвөрхангай аймгийн Хархорин сумын хэрэглэгчдийг ухаалаг тоолуурт шилжүүлэх, 0,4 кВт-ын шугам сүлжээг шинэчлэх, Орхон аймгийн Баян-Өндөр суманд 35/6 кВт-ын дэд станцын барилга угсралтын ажлууд хийгдэхээр тусгагдсан байна.

Жилийн 3%-ийн хүүтэй, 40 жилийн хугацаатай, 16,187,000 ам долларын төсөл хэрэгжих бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 11 бараа, ажил үйлчилгээ, зөвлөхийн гэрээ байгуулагдаж, 3 барилга угсралтын ажил эхэлж 2,519,230.47 ам долларын зээл олгогдсон байна. Аудитын явцад эдгээр асуудлыг хянасан ба анхаарал татахуйц асуудлын хүрээнд авч үзлээ.

Мөн Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалаар батлагдсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу 2018 онд 184,711.92 м.кв талбайтай 547 ширхэг барилга, цахилгаан дамжуулах, хуваарилах байгууламжуудын газрыг үнэлэн санхүүгийн тайланд тусгасан боловч 124 газрын гэрчилгээ бүрэн гаргаагүй, газар эзэмших эрх нь тус компанид байгаа боловч, хөрөнгө нь бусдын эзэмшилд мөн газрын үнэлгээ хийгдээгүй зэрэг шалтгаанаар бүртгэлд тусгагдаагүй байна. Иймд эдгээр асуудлыг 2020 оны аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 62 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 14.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 266.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснээс 235.2 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Дутуу хэрэгжсэн 30.8 сая төгрөгийн албан шаардлага нь авлагын барагдуулалттай холбоотой байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу хэрэгжилт 98.0 хувьтай байна. Энэ нь үнэлгээнд хамруулаагүй 54 газар эзэмших эрхийг үнэлэн 2019 онд санхүүгийн тайланд тусгахаар “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлтээ хүргүүлсэн боловч, газар эзэмших эрхийг үнэлж, тайланд тусгах аргачлалыг боловсруулж дуусаагүй тул 2020 онд энэ ажлыг хэрэгжүүлнэ” гэсэн хариу өгсний дагуу хүлээгдэж байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 1,088.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 1,243.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

**3.1.1 Илрүүлэлт:** Ашиглалтад тавьж олгон, зарцуулагдсан 358 нэр төрлийн 118.6 сая төгрөгийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь НББОУС 2 Бараа материал стандартын 6-д Бараа материал гэдэг нь дараах хөрөнгүүд юм: (в) “үйлдвэрлэлийн процесст эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.1.2 Эрсдэл: Зардлыг дутуу бүртгэсэн байх**

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** НББОУС 2 Бараа материал стандартад заасны дагуу бараа материалыг ашиглалтад тавьж олгон, зарцуулсан тухай бүр данснаас хасах

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Ашиглалтад тавьж олгосон хангамжийн материалыг данснаас хасаж залруулна.

#### **3.2. Орлогын данстай холбоотой асуудал**

**3.2.1 Илрүүлэлт:** Техникийн нөхцөл олголтын хураамжийн 10.3 сая төгрөгийн орлогыг аккруэл сууриар авлага үүсгэн бүртгээгүй, орлого хураалтад тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.2.2 Эрсдэл: Орлогыг аккруэл сууриар бүртгээгүй байх, дутуу төвлөрүүлэх;**

**3.2.3 Өгсөн зөвлөмж:** Техникийн нөхцөл олголтын хураамжийн орлогыг аккруэл сууриар бүртгэж, хяналтыг сайжруулах

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийн дагуу орлогыг аккруэл сууриар бүртгэж, хяналтыг сайжруулан ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн Санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,624,423,589.78	1,675,983,259.92
1.1.2	Дансны авлага	12,200,617,639.08	11,575,043,579.84
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	14,078,239.39	19,035,558.18
1.1.4	Бусад авлага	135,337,888.19	87,532,353.33
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,473,655,185.39	2,640,401,788.96
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	449,180,771.64	1,241,927,682.26
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>18,897,293,313.47</b>	<b>17,239,924,222.49</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	115,295,925,270.93	125,566,587,649.50
1.2.2	Биет бус хөрөнгө	2,655,792,997.27	2,690,875,285.28
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	167,656,396.08	273,014,547.89
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>118,119,374,664.28</b>	<b>128,530,477,482.67</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>137,016,667,977.75</b>	<b>145,770,401,705.16</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	12,252,880,385.03	10,750,594,041.26
2.1.1.2	Цалингийн өглөг	12,348,975.58	2,860,000.00
2.1.1.3	Татварын өр	195,063,229.76	105,752,271.07
2.1.1.4	НДШ–ийн өглөг		6,179,815.28
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	138,271,337.11	76,618,652.14
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	209,912,293.42	182,652,068.83
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	51,900,749.88	25,477,783.53
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>12,860,376,970.78</b>	<b>11,150,134,632.11</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	359,321,999.10	6,923,631,343.20
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	409,587,934.86	424,816,491.47
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,024,175,091.50	3,227,810,061.34
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4,793,085,025.46</b>	<b>10,576,257,896.01</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>17,653,461,996.24</b>	<b>21,726,392,528.12</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	119,534,968,376.11	41,896,959,300.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		82,711,275,017.35
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,574,667,240.00	2,574,667,240.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,746,429,634.60)	(3,138,892,380.31)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>119,363,205,981.51</b>	<b>124,044,009,177.04</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>137,016,667,977.75</b>	<b>145,770,401,705.16</b>



#### 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>219,174,650,151.06</b>	<b>247,742,561,160.55</b>
2	Борлуулалтын өртөг	208,732,097,538.72	236,497,685,763.07
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>10,442,552,612.34</b>	<b>11,244,875,397.48</b>
4	Түрээсийн орлого	21,600,000.00	21,600,000.00
5	Хүүгийн орлого	379,945,299.42	228,596,539.29
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	932,305,688.51	724,370,790.45
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,076,901,812.23	4,247,794,751.74
10	Ерөнхий ба удирдлагын зардал	6,801,909,443.58	7,112,812,569.82
11	Санхүүгийн зардал	3,479,946.84	37,904,465.76
12	Бусад зардал	535,452,296.71	651,607,894.59
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(9,896,480.45)	(25,518,596.75)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(80,690,909.24)	23,364,777.17
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>268,072,711.22</b>	<b>167,169,225.73</b>
19	Орлогын татварын зардал	59,775,081.09	68,773,704.93
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>208,297,630.13</b>	<b>98,395,520.80</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>208,297,630.13</b>	<b>98,395,520.80</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>208,297,630.13</b>	<b>98,395,520.80</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	119,534,968,376.11	-	-	736,209,751.15	120,271,178,127.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(3,679,173,255.88)	(3,679,173,255.88)
Залруулсан үлдэгдэл	119,534,968,376.11	-	-	(2,942,963,504.73)	116,592,004,871.38
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				208,297,630.13	208,297,630.13
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			2,574,667,240.00		2,574,667,240.00
Зарласан ногдол ашиг				11,763,760.00	11,763,760.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	119,534,968,376.11	-	2,574,667,240.00	(2,746,429,634.60)	119,363,205,981.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(82,251,661,395.84)	82,711,275,017.35		(459,613,621.51)	0.00
Залруулсан үлдэгдэл	37,283,306,980.27	82,711,275,017.35	2,574,667,240.00	(3,206,043,256.11)	119,363,205,981.51
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-	98,395,520.80	98,395,520.80
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт	4,613,652,319.73				4,613,652,319.73
Зарласан ногдол ашиг				31,244,645.00	31,244,645.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	41,896,959,300.00	82,711,275,017.35	2,574,667,240.00	(3,138,892,380.31)	124,044,009,177.04

#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>220,455,233,581.50</b>	<b>250,088,769,738.43</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	218,358,350,783.23	248,157,560,436.69
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,096,882,798.27	1,931,209,301.74
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>217,752,726,558.58</b>	<b>247,850,213,927.36</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	8,737,386,326.47	8,544,345,312.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,496,060,786.71	2,580,971,300.28
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	199,113,050,316.37	228,361,430,364.85
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	81,489,126.69	88,921,390.37
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,403,018,561.00	1,269,899,534.73
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	8,515,471.20	335,297,411.11
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,829,724,718.25	3,183,646,755.76
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,444,827.00	16,977,668.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,074,036,424.89	3,468,724,189.38
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,702,507,022.92</b>	<b>2,238,555,811.07</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>379,945,299.42</b>	<b>271,396,539.29</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		42,800,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	379,945,299.42	228,596,539.29
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,176,399,716.00</b>	<b>4,425,969,271.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,176,399,716.00	4,361,029,271.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		64,940,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		

2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,796,454,416.58)</b>	<b>(4,154,572,731.71)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>23,501,366.80</b>	<b>32,797,331.20</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	11,737,606.80	1,552,686.20
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	11,763,760.00	31,244,645.00
3.2.5			
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(23,501,366.80)</b>	<b>(32,797,331.20)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>827,735.56</b>	<b>373,921.98</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,116,621,024.90)</b>	<b>(1,948,440,329.86)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,741,044,614.68</b>	<b>3,624,423,589.78</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,624,423,589.78</b>	<b>1,675,983,259.92</b>

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	<b>2020.03.10</b>	Аудитын нэр:	<b>2019 оны санхүүгийн аудитын тайлан</b>	Аудитын код:	
				САГ-2020/46/СТА-ТӨҮГ	
Шалгагдсан байгууллагын нэр:		<b>Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит</b>			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус компанийн өмчлөлийн Булган аймгийн Хялганат тосгонд байрлах 43.3 сая төгрөгийн өртөгтэй 2 давхарт байрлах 2 өрөө байрыг 2013 онд 1 давхрын 2 өрөө байраар сольж үйл ажиллагаагаа явуулж байсан боловч тус байрны өмчлөгч 1 давхрын байраа буцаан авахаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Анхан шатны шүүхийн шийдвэрээр Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг албадан гаргах шийдвэр гаргасан байна.	43.3	Албан шаардлага	Хуулийн зөвлөх	С.Энхбат
2	Ашиглалтад тавьж олгон, зарцуулагдсан 358 нэр төрлийн 118.6 сая төгрөгийн бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	118.6	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч, Материал хариуцсан нягтлан бодогч	Г.Батгэрэл, Н.Мөнхчимэг
3	Бэлтгэн нийлүүлэгчид болон хувь хүнтэй холбоотой 7 харилцагчийн 64.2 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний борлуулалттай холбоотой 42 харилцагчийн 12.6 сая төгрөг, нийт 76.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	76.8	Албан шаардлага	Ахлах нягтлан бодогч, Борлуулалтын нягтлан бодогч	Г.Батгэрэл, Б.Шийлэгмаа
4	Техникийн нөхцөл олголтын хураамжийн орлогыг аккруэл сууриар авлага үүсгэн бүртгээгүй, 10.3 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан, орлого хураалтад тавих хяналт хангалтгүй байна.	10.3	Зөвлөмж өгөх	Техникийн Бодлогын хэлтсийн дарга, Борлуулалтын нягтлан бодогч	Б.Амарбаясгалан, Б.Шийлэгмаа

5	Аваарын нөөцөд бүртгэлтэй трансформаторуудаас түүвэрлэн биет тооллого хийхэд ТМ-35/15 1000 кв маркийн 43.6 сая төгрөгийн трансформатор биетээр оршин байхгүй байсан. Тус трансформаторыг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн улмаас Говь-Алтай аймгийн Жаргалан, Баян-Уул зэрэг сумууд сар гаруй хугацаанд цахилгаан хангамжгүй болсон тул Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-д Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр шилжүүлсэн байна.	43.6	Албан шаардлага	Техникийн Бодлогын хэлтсийн дарга, Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч	Б.Амарбаясгалан, О.Анхтуяа
6	Тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангаагүй 795.5 сая төгрөгийн 11 оролцогчийг тендерт шалгаруулсан, тендерийн баримт бичгийн зарим заалтуудыг алдаатай боловсруулсан, тендерийн урилгад ирүүлэхээр заагдсан баримтыг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгаагүй, нээлтийн хурлын тэмдэглэлийг хуулийн дагуу хөтлөөгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.	795.5	Албан шаардлага	ХҮХ-ийн дарга Тендерийн үнэлгээний хороо	Д.Гэрэлмаа Үнэлгээний хорооны дарга, гишүүд
7	Тайлант онд 250,007.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан байхад гүйцэтгэлээр 248,717.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 1,290.1 сая төгрөг буюу 0.5 хувиар орлогыг төлөвлөгөөг тасалдуулсан		Албан шаардлага	Борлуулалтын хэлтсийн дарга	Ш.Дайрийжав
	<b>Нийт дүн</b>	<b>1,088.1</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18 № 02/119  
САР-2020/46/СТА-ТӨЧГ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус компанийн өмчлөлийн Булган аймгийн Хялганат тосгонд байрлах 43,259.3 мянган төгрөгийн өртөгтэй 2 давхарт байрлах 2 өрөө байрыг хэрэглэгчдийн үйлчлэхэд хялбар гэж үзэн 2013 онд 1 давхрын 2 өрөө байраар сольж одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байсан боловч тус байрны өмчлөгч 1 давхрын байраа буцаан авахаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Анхан шатны шүүхийн шийдвэрээр Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг албадан гаргах шийдвэр гаргасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.
2. Бэлтгэн нийлүүлэгчид болон хувь хүнтэй холбоотой 7 харилцагчийн 64,221.3 мянган төгрөг, цахилгаан эрчим хүчний борлуулалттай холбоотой 42 харилцагчийн 12,570.0 мянган төгрөг, нийт 76,791.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.
3. Аваарын нөөцөд бүртгэлтэй трансформаторуудаас түүвэрлэн биет тооллого хийхэд ТМ-35/15 1000 кв маркийн 43,600.0 мянган төгрөгийн трансформатор биетээр оршин байхгүй байсан. Тус трансформаторыг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн улмаас Говь-Алтай аймгийн Жаргалан, Баян-Уул зэрэг сумууд сар гаруй хугацаанд цахилгаан хангамжгүй болсон тул Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-д Төрийн өмчийн бодлого

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

4. зохицуулалтын газрын шийдвэргүйгээр шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.
5. Тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангаагүй 795,530.5 мянган төгрөгийн 11 оролцогчийг тендерт шалгаруулсан, тендерийн баримт бичгийн зарим заалтуудыг алдаатай боловсруулсан, тендерийн урилгад ирүүлэхээр заагдсан баримтыг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгаагүй, нээлтийн хурлын тэмдэглэлийг хуулийн дагуу хөтлөөгүй зэрэг зөрчлүүд илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ” 27.1.1-д “энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага” 27.1.2-д “техникийн тодорхойлолт” 27.1.3-д “тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага” 27.3-т “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” 27.4-д “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.
6. Тайлант онд 250,007.2 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан байхад гүйцэтгэлээр 248,717.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 1,290.1 сая төгрөг буюу 0.5 хувиар орлогыг төлөвлөгөөг тасалдуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Захирал дараах эрх, үүрэгтэй”, 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**




1. Булган аймгийн Хялганат тосгонд байрлах 43,259.3 мянган төгрөгийн өртөгтэй 2 давхарт байрлах 2 өрөө үл хөдлөх хөрөнгийг буцаан авах;
2. Авлагын данстай холбоотой 76,791.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, барагдуулах арга хэмжээ авах, алдаа зөрчлийн давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;
3. Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-д шилжүүлсэн трансформаторыг эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн балансаас балансад шилжүүлэх;



*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харилцагч албан тушаалтанд харилцаагаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*



4. Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангасан оролцогчийг тендерт шалгаруулах, тендерийн баримт бичигт тусгагдсан заалтуудыг боловсронгуй болгох, тендерийн үнэлгээг хуулийн дагуу хийж оролцогчийг сонгон шалгаруулах, тендерийн хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллах;
5. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах;
6. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Баярцогт, Ерөнхий нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

**ТОГТООСОН:**  
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР  Д.БОЛОР-ЭРДЭНЭ  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  Т.ОДОНЧИМЭГ

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Г.БАЯРЦОГТ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ  Б.НАРАНЦЭЦЭГ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*





